

# “АРИГ БАНК” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН

## П.МӨНХ-ЭРДЭНИЙН 2021 ОНЫ 04 ДҮГЭЭР УЛИРЛЫН АЖЛЫН ТАЙЛАН

2022 оны 01 дүгээр  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 5176 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам"-ын 5 дугаар зүйлийн 5.1-т заасны дагуу 2021 оны 04 дүгээр улирлын ажлын тайланг хүргүүлж байна. Тайлант хугацаанд Ариг банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал, хойшлогдсон хурал 4 удаа, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал 5 удаа хуульд заасны дагуу танхимаар, цахимаар, эчнээ санал хураалтын хэлбэрээр хуралдаж, Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрүүдийг гарган ажилласан байна. Үүнээс:

### Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус болон хойшлогдсон хурлууд:

“Ариг банк” ХХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.9-д “Хувьцаа эзэмшигчдийн хурлыг ТУЗ-ийн дарга удирдана” гэж заасны дагуу тайлант хугацаанд хуралдсан хувьцаа эзэмшигчдийн 4 хурлын 2-ыг даргалж, хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ хугацаанд товлогдсон хурлын даргаар КТХ-ийн 60 дугаар зүйлийн 60.2.8, 60.5 дугаар зүйлд зааснаар орлох этгээдээр ТУЗ-ийн гишүүн С.Сайнбатыг томилон даргалуулсан.

- 2021-10-04-ний өдөр хуралдсан ХЭЭБХ – хурлыг ТУЗ гишүүн С.Сайнбат даргалсан, хувьцаа эзэмшигч “Дэм санхүүгийн нэгдэл” ХХК-ийн төлөөлөл хуралд ирээгүй, хурал хууль болон дүрэмд заасан ирц бүрдээгүй учир хойшлогдсон хурлыг зарлан хуралдуулсан.
- 2021-10-15-ны өдөр хуралдсан ХЭЭБХ /хойшлогдсон/ - хурлыг ТУЗ гишүүн С.Сайнбат даргалсан, хурлаар 2 асуудал хэлэлцүүлэхээр батлагдсан байснаас хувьцаа эзэмшигч “Дэм санхүүгийн нэгдэл” ХХК ирээгүй учир ТУЗ гишүүнийг сонгох асуудлыг хэлэлцүүлээгүй орхиж, “Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээрт заасан төлөвлөгөөг хувьцаа эзэмшигч “Улаанбаатар импэкс” ХХК-ийн төлөөлөл дахин батлан тогтоол гаргасныг Монголбанк болон СЗХ руу хүргүүлсэн.
- 2021-11-24-ний өдөр хуралдсан ХЭЭБХ – хурлыг миний бие даргалсан, хувьцаа эзэмшигч “Дэм санхүүгийн нэгдэл” ХХК-ийн төлөөлөл хуралд ирээгүй, хурал хууль болон дүрэмд заасан ирц бүрдээгүй учир хурлаас тогтоол шийдвэр гаргаагүй.
- 2021-12-20-ны өдөр хуралдсан ХЭЭБХ - хурлыг миний бие даргалсан хувьцаа эзэмшигч “Дэм санхүүгийн нэгдэл” ХХК-ийн төлөөлөл хуралд ирээгүй, хурал хууль болон дүрэмд заасан ирц бүрдээгүй учир хурлаас тогтоол шийдвэр гараагүй.

### Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлууд:

- 2021 оны 10 дугаар сард 1 удаа хуралдаж, хурлаар 2021-10-04-ний хуралдахаар товлож байсан ХЭЭБХ-ыг хойшлуулан 2021-10-15 өдрийн 10 цагаас хуралдуулахаар товлож Т/39 дугаартай тогтоолыг гаргасан.
- 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр хуралдаж доорх тогтоолуудыг батласан. Үүнд:
  - “Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчид чөлөө олгох тухай” Т/40 дугаар тогтоол;
  - “Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчийг орлон ажиллах ажилтныг томилох тухай” Т/41 дугаар тогтоол;
  - “NES” системийг худалдан авах, банкны суурь програмаар нэвтрүүлэх зөвшөөрөл олгох тухай” Т/42 дугаар тогтоол;
  - “Өмчлөх бусад хөрөнгөд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах зөвшөөрөл олгох тухай” Т/43 дугаар тогтоол;

- “Өмчлөх бусад хөрөнгийн зах зээлийн үнийг тогтоох тухай” Т/44 дугаар тогтоол;
- 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр хуралдаж доорх тогтоолуудыг батласан. Үүнд:
  - “2021 оны санхүүгийн тайланд аудит хийх хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох тухай” Т/45 дугаар тогтоол;
  - “ХЭЭБХ-ыг зарлан хуралдуулах, хэлэлцэх асуудлыг батлах тухай” Т/46 дугаар тогтоол;
- 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн ТУЗ даргын гаргасан “ТУЗ-ийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай” Т/47 дугаар тогтоол;
- 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдөр хуралдаж доорх тогтоолуудыг батласан. Үүнд:
  - “Зарласан хувьцааны тоонд багтаан хувьцаа эргэлтэнд гаргах тухай” Т/48 дугаар тогтоол;
  - “Банкны 2021-203 оны стратеги төлөвлөгөө, бүтэц зохион байгуулалтыг шинэчлэн батлах тухай” Т/49 дугаар тогтоол;
  - “ТУЗ-ийн дэргэдэх дотоод аудитын газрын захирлыг томилох” Т/50 дугаар тогтоол;
  - “Өмчлөх бусад хөрөнгөд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийн үнэ тогтоох, худалдан борлуулах зөвшөөрөл олгох тухай” Т/51 дугаар тогтоол;
  - “ХЭЭБХ-ыг хуралдуулах, хэлэлцэх асуудлыг батлах тухай” Т/52 дугаар тогтоол;
- 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн ТУЗ даргын гаргасан “ТУЗ-ийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай” Т/53 дугаар тогтоол;
- 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр хуралдаж доорх тогтоолуудыг батласан. Үүнд:
  - “Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчид чөлөө олгох, түүнийг орлох этгээдийг томилох тухай” Т/54 дугаар тогтоол;
  - “Хувьцаа худалдан авах санал ирүүлсэнд тооцох, гарын үсэг зурах эрх олгох” Т/55 дугаар тогтоол;
  - “Татгалзсанд тооцох тухай” Т/56 дугаар тогтоол;
  - “ХЭЭБХ-ыг зарлан хуралдуулах, хэлэлцэх асуудлыг батлах тухай” Т/57 дугаар тогтоолуудыг тус тус гаргах, шийдвэр гаргалтанд оролцож ажилласан.

Түүнчлэн “Ариг банк” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны даргаар, Эрсдэл удирдлагын хороо болон Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хорооны гишүүнээр ажиллаж байгаа бөгөөд 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр болон 2021 оны 12 дүгээр сарын 08-ны өдрүүдэд Эрсдэл удирдлагын хорооны хуралд оролцож шийдвэр гаргасан.

- 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн хурлаар банкны өмчлөх бусад хөрөнгөд бүртгэлтэй 10 үл хөдлөх хөрөнгийн асуудлыг авч хэлэлцэн, 4 ҮХХ-ийг худалдан борлуулах зөвшөөрөл олгосон ЭУХ/04 дугаартай тогтоол, 6 ҮХХ-ийн үнэлгээг тогтоож худалдах ЭУХ/05 дугаартай тогтоолыг гаргасан.
- 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хурлаар банкны өмчлөх бусад хөрөнгөд бүртгэлтэй 3 үл хөдлөх хөрөнгийг худалдах ЭУХ/06 дугаартай тогтоол гаргасан.

ТАЙЛАН БИЧСЭН:

Төлөөлөн удирдах зөвлөлийн

хараат бус гишүүн ..... П.Мөнх-Эрдэнэ

